



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 01 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

### **1/8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалт:**

“8.2.6.хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслийн жолоочийн ажиллах, амрах горим, хөдөлгөөний хурдны хязгаарлалтыг баримталж байгаа эсэхийг хяналтын төхөөрөмжийн мэдээлэлд үндэслэн шалгаж тогтоох.”

### **2/10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалт:**

“10.1.9.хяналтын төхөөрөмжийн хяналт, зохицуулалтын бүртгэл, мэдээллийн санд хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төхөөрөмжийн засвар, үйлчилгээний байгууллагын бүртгэл, ашиглалт, засварын түүх, картын бүртгэл, мэдээллийг хамруулах.”

**2 дугаар зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “10.1.1-д” гэснийг “10.1.1, 10.1.9-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг “Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын Европын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР